



## МОНГОЛЫН НОГООН НАМ

"Элит офис", 201 тоот  
Сүхбаатар дүүрэг, I хороо, Утас/факс: 70110680  
И-мэйл: info@mongoliangreenparty.mn

УИХ-ЫН ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

2014.06.20 № 01/51

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


### Шаардлага хүргүүлэх тухай

Тус намаас УИХ-д суудалгүй намуудын дунд улс эх орны тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг байнга зохион байгуулан намууд хоорондын хамтын ажиллагааг өрнүүлж ирсэн бөгөөд энэ нь улс төрийн намуудын үйл ажиллагааг нь идэвхижүүлж байгаа болно.

Өнөөгийн "шинэчлэлийн" гэх тодотголтой Засгийн газар нь Монгол улсын тулгуур эрх ашиг, ард түмний хүсэл эрмэлзэлд хөнгөн хийсвэр хандсан үйл ажиллагаа явуулж байгаа тул Монголын ард түмний итгэл үнэмшлийг өвөрлөн төр засаг, улс эх орноо удирдан чиглүүлэх хүндэт үүрэг бүхий УИХ-д хандсан, "Засгийн газрыг огцруулах тухай шаардлага"-ыг УИХ-д суудалгүй намуудын нэрийн өмнөөс УИХ-ын дарга Танд хүргүүлж байгаа болно.

Гүнээ хүндэтгэсэн,

Дарга



О.Бум-Ялагч

# ПАРЛАМЕНТЫН БУС НАМУУД

2014 оны 6 дугаар сар 18-ны өдөр

№ 01/02

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

Засгийн газрыг огцруулах тухай шаардлага

Төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, монголын ард түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх зарчимд үндэслэдэг.

Сүүлийн үед Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, монголын ард түмний оршин тогтнолын үндсэн баталгаа болох Монголын газар нутагт аюул занал учруулсан хууль тогтоомж батлуулах ородлого гарч, ард түмний эрх ашигт харш үйлдэл хийгдэж буйн улмаас УИХ-ын дарга Танд ийнхүү хандаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж тодорхой заасан байдаг.

Ард түмний мэдэлд байна гэдгийг Монгол орны байгалийн баялгийг хэрхэн ашиглах талаарх аливаа шийдвэрийг иргэдийн бодитой оролцоотойгоор гаргаж, зөвхөн ард түмний сайн сайхны төлөө ашиглахыг хэлж байна гэж бид хатуу ойлгоно.

Түүнчлэн, “төрийн хамгаалалтанд байна” гэдгийг энэхүү баялгийг хэрхэн ашиглах талаарх стратегийн ач холбогдол бүхий шийдвэрийг Үндсэн хуульдаа нийцүүлэн гаргах эрх мэдэл гагцхүү ард түмнээс сонгогдсон УИХ-д байх ёстой гэж ойлгоно.

Гэтэл УИХ-аас томилсон Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, түүний тэргүүлсэн Засгийн газар нь Монгол Улсын Тусгаар Тогтнол, Аюулгүй байдал, Монголын ард түмний эсрэг чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж ирлээ.

ЗГ-аас боловсруулж УИХ-д өргөн барьсан “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, шинэчлэн найруулсан Газрын тухай хуулийн төсөл зэрэг нь үндэсний эрх ашгаас урваж, Монгол Улсын тусгаар тогтнолыг үгүй хийх санаа зорилгыг агуулсан байна.

Энэхүү хуулийн төсөлд улсын хилийн зурвас газрын талаар шийдвэр гаргахыг УИХ-ын бүрэн эрхээс хасч (8.1.3), “цацраг идэвхт ашигт малтмал олборлох, тээвэрлэх, хадгалахтай холбогдсон тусгай дэглэм тогтоох” бүрэн эрхийг (8.1.6) нь хүчингүй болгосон байна. Улсын хилийн зурваст ашигт малтмалыг эрэхээс ашиглах хүртэл үйл ажиллагаа эрхлэх асуудлыг Үндэсний геологийн алба гэгчийн мэдэлд өгөх (9.1.12) сонирхлоо хуульчлах гэж байна. Ингэснээр Монголын Төрийг улсынхаа дархан хилийн зурвасыг мэдэх эрхгүй, цацраг идэвхит ашигт малтмалын аюулгүй байдлыг хангах үйл

ажиллагааг эзэнгүй, эцсийн бүлэгт Монгол Улсыг Төргүй болгох зорилгыг агуулсан гэж үзэн, эсэргүүцэж байна.

Дээрх хуультай хамт өргөн барьж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь газар өмчлөлийг чөлөөлж гадаадын этгээдэд нээж өгөхийг зорьж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар эзэмших эрхийг зөвхөн нээлттэй дуудлага худалдааны үндсэн дээр олгоно гэж сүрхий хязгаарлалттай заалт (15.5) хийсэн дүр эсгэж, дуудлага худалдаагаар газар эзэмших эрх авсан бол тэргүүн ээлжинд тухайн газрыг үнэгүй өмчлөх эрхийг (27.1.7) баталгаажуулсан байх юм. Бэлчээрийн газрыг эзэмшүүлэх тухай заалтууд (22-р зүйл) нь Үндсэн хуулийн заалт (6.3)-ыг зөрчиж, олон мянган жилийн туршид хөгжиж ирсэн нүүдлийн мал аж ахуйн нарийн харилцаа, соёл иргэншилд халгаатай болохыг анхааруулж байна.

Түүнчлэн, удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй, монголын иргэдийн нилээд хэсэг ядууралд нирвэгдсэн, нөгөө хэсэг нь ашиг хонжооны хойноос улайран хөөцөлдөх болсон орчинд “Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно” гэсэн Үндсэн хуулийн заалт биелэхгүй магадлалтайг сануулж байна.

Хамгийн ноцтой нь дээрх хуулийн төслүүд нь монгол хүний эрх ашгийг хамгаалсан арга хэмжээнүүдийг хангалттай тусгаагүй явдал юм гэж үзэж байна. Санал болгож буй хуулийн төслүүд нь газрын талаарх төрийн нарийн бодлого, газрын удирдлагын өндөр чадавхи, газар өмчлөлийн либералчлалыг тэнцвэржүүлэх хяналтын тогтолцоо зэрэг үндсэн нөхцлүүдийг хангаагүй байгаа бөгөөд авлига газар авсан үед үндэсний язгуур эрх ашигт аюул учруулахыг цохон тэмдэглэж байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах суманд мал олноор үхэж, ургийн гажигтай үр төл гарч, иргэд ус бэлчээрээ хамгаалахаар тэмцэж, Засгийн газартаа хандан хүсэлт шаардлагуудаа тавьсаар байгааг үл тоомсорлон, эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн төлөвлөгөө гэгчдээ бүр “Ураны салбарт ажиллаж буй компаниудад учирч буй саад гацааг арилгах” зорилт тавьсан нь энэ Засгийн газар Монголын ард түмний эсрэг ажиллаж байгааг нотлох нэгэн баримт мөн.

Эвсэлийн Засгийн газрын явуургүй үйл ажиллагааг шүүмжилж буй жирийн иргэдийн эсэргүүцэл нь иргэний ухамсар, хүний эрхийн зүй ёсны илэрхийлэл юм. Хэнбугайд алив гэм хор учруулаагүй, гагцхүү эх орон, хууль эрхээ хамгаалан тэмцсэн иргэдээ шоронд хийж, эрх баригчдын зүгээс хэвлэл мэдээллээр айлган сүрдүүлэх, янз бүрийн арга хэлбэрээр дарамтлах явдал нэмэгдэж байгааг эрс буруушааж байна.

Н.Алтанхуягийн Засгийн газар урьд өмнө Монголын түүхэнд байгаагүй хамгийн их төсвийг олигтой захиран зарцуулж чадаагүй үрэн таран хийгээд зогсохгүй улс орноо ахар богино хугацаанд мөн л өмнө байгаагүй асар том өрөнд унагасан нь үнэн. Манай улсын гадаад валютын нөөцийг 2,9 тэрбум ам. доллартай хүлээн авч ганцхан жилийн дотор хоёр дахин багастал үгүй хийж, гурван их наяд төгрөгийг төсвөөс гадуур хэвлэн үнэ тогтворжуулах нэрээр гүйлгээнд оруулж, хомсдлыг ашиглан валютын ханшийг хиймлээр өсгөн тоглож мөнгө хүүлэх боломжийг бий болгож байгааг Н.Алтанхуягийн Засгийн газрын гайтай үйл ажиллагаа гэхээс өөр аргагүй. Хийж бүтээсэн гээд байгаа

ажлуудын зарим нь одоогийн Засгийн газарт хамаагүй, ихэнх нь зарцуулсан мөнгөтэй харьцуулахад дэндүү чамлалттай болохыг тэмдэглэж байна.

Засгийн газар чадваргүй, хариуцлагагүй үйл ажиллагааных нь улмаас улс орны эдийн засаг хямарч, ядуурал даамжирч, хөгжлийн зорилтууд биелэхгүй байгаа бодит байдлаас олон нийтийн анхаарлыг холдуулах зорилгоор хагас дутуу боловсруулсан хуулийн төсөл өргөн барихаас улс төржсөн мэдэгдэл хийх хүртэл янз бүрийн улс төрийн шоу тавьж олон нийтийг бужигнуулж байгааг шүүмжилж байна.

Эрх баригч улс төрийн хүчин нь шоу хийгээд зогсохгүй Монгол орон, ард түмний эрх ашгийг огоорч, Монголын газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, ард түмний хувь заяаг барьцаанд өгөхийг санаархаж байгааг үндэслэн Парламентад Суудалгүй Намуудаас ШААРДАХ нь:

1. УИХ-аас Монголын газар нутаг, байгалийн баялагтай холбоотой дээрх хуулийн төслүүдийг өнөөгийн байгаа байдлаар батлахгүй байхыг;
2. Эдгээр хуулийн төслийг дахин боловсруулах ажилд парламентад суудалгүй намууд, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллагуудыг оролцуулж, төслийг олон нийтээр үндэсний хэмжээнд ардчилсан ёсоор хэлэлцүүлэхийг;
3. Энэ Засгийн газрын увайгүй үйл ажиллагааны улмаас цөөхөн бидний монголчууд эх оронгүй үлдэх магадлал өндөр байгаа тул Засгийн газрыг огцруулахыг;
4. Уг мэдэгдэл шаардлагад өгөх хариуг 2014 оны 6-р сарын 28-ны дотор бичгээр хүргэхийг.

ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН НАМУУД:

МОНГОЛЫН НОГООН НАМ

ХАМУГ МОНГОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН НАМ

БҮГД НАЙРАМДАХ НАМ

ЭХ ОРОНЧДЫН НЭГДСЭН НАМ

ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН НАМ

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ

ЛИБЕРАЛ НАМ

КОНСЕРВАТИВ НАМ

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ

МОНГОЛЫН СОЦИАЛ ДЕМОКРАТ НАМ

